

**"МОН-НАБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

"МОН-НАБ" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 18 -ны өдөр Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 6-р хороо Жуулчны гудамж -19, Хишиг төв 7 давхар 701 тоотод болов.

Хурал 14.00 цагаас эхлэж ТУЗ —н дарга Р.Зоригт даргалан явуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хувьцаа эзэмшигч:

- Т. Бадамжунай / 62400 ширхэг хувьцаа эзэмшигч/
 - Р.Зоригт / 37497 ширхэг хувьцаа эзэмшигч/
- нар тус тус хүрэлцэн ирсэн

ТУЗ- н гишүүд :

- Ш.Оюун-Эрдэнэ
- Г.Төгөлдөр
- Д.Болорцэцэг
- Л.Амарсайхан
- Р.Алтанцэцэг
- Л.Мөнхтуяа

нар хүрэлцэн ирж ирц 81,3 % байна гэж хурал зохион байгуулах комиссийн гишүүн Г.Төгөлдөр танилцуулав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн болно. Үүнд:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны , санхүүгийн байдалд ТУЗ-н өгсөн дүгнэлт ;
- ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлах;
- Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг хэлэлцэж батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хуралд "Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд ТУЗ-ийн хийсэн дүгнэлт" - ийг ТУЗ-ийн дарга Р.Зоригт танилцуулж, дараах нэмэлт тайлбарыг хийв.

ХЭХуралд ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчид 2023 онд ээлжит болон ээлжит бус хурлаа хийсэн.

Компанийн өнөөгийн байдал хүндхэн байгаа өдөр тутмын асуудлыг шийдвэрлэж байгаа ч бүх зардлууд нэмэгдсэн байна. Жил бүр төлдөг урсгал зардлуудыг эзний өөрийн хөрөнгөөр төлж барагдуулж байгаа. Өр төлбөрөө бага багаар төлж барагдуулж л байна Санхүүгийн байдал хүнд дандаа эзний хөрөнгөөр төлбөр барагдуулна гэдэг асуудалтай. СЗХороо, Хөрөнгийн Биржээс ирүүлсэн албан тоот, даалгаваруудад хариу өгөх талаар их анхаарч ажилласан. Компанийн гадна дулааны ажлыг хийж байгаа хүмүүс ажлаа дуусаагүй өвөлжлөө дотор дулааны шугамын засварын ажил дулааны үзэлийн барилга засвар хийх шаардлагатай байгаа. Манай ойр хавийн байгууллагуудын дулаан авдаг төв шугам дахин хагарч бүгд нийлж хагарсан шугамыг солисон . Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан санал шүүмжлэл дараах байдлаар өрнөв. Үүнд:

Р.Зоригт: Компанийн үйл ажиллагааг бол барилгын чиглэлийг нь хадгалаад явна гэсэн бодолтой байгаа. Хувьцаат компанийн хувьд өөр чиглэлийн ажил хийнэ гэдэг хэцүү.

Ш.Оюун-Эрдэнэ: ХЭХурлын зар хүргэх журмын дагуу явагддаг зарим нэг хүн бүр онцолж хэлбэл Дармаа гуай биеийн байдал нь хүнд хувийн асуудлаа компанитай хольж янз бүрийн юм ярьж энд тэнд асуудал үүсгэн явсан бид хүлээцтэй хандсан. Бид олон нийтийн сонин хэвлэл, брокер пүүс, утсаар хүртэл яриад байхад хуралд ирэх нь цөөхөн байна. Хувьцаа эзэмшигчид хурлын зар, бичиг баримт хуралд хэлэлцэх асуудал, байгууллагын өнөөгийн байдлын талаар мэдээллийг олон сувгаар авах боломжтой.

ТУЗ -н гишүүд үүргийнхээ дагуу ажилмаар байна. Хэдий санхүүгийн боломж муу байгаад цалин урамшуулал өгч чадахгүй байгаа ч та нарт сэтгэл дутаж байна уу даа гэж харагдаж байна шүү.

Цаашид орон тоо цалин урамшуулалын талаар бодож шийдвэрлэх юм их байна.

Р.Алтанцэцэг: Санхүүгийн тайлан аудит хийлгэх ажил гэрээний дагуу "Ай Жэй Эй Эйч-АУДИТ"ХХК –аар аудитын гэрээ хийж дүгнэлт гаргуулсан төлбөр мөнгө нэмэгдсэн хойшид хамтран ажиллах болно. Энэ байгууллагын ажил төрөл ямар байдлаар яаж ашигтай ажиллуулбал зүгээр талаар оновчтой санал хэлэх хүн байна уу.

Ш.Оюун-Эрдэнэ Компанийн ТУЗ н гишүүд цаашид хариуцсан чиглэлээр санал санаачлага гаран ажилмаар байна. Компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдах хэрэгтэй байна. Энийг СЗХорооноос шаардаад байгаа.

Д.Болорцэцэг: Үндсэн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл энээ тэрээ юм шаарддаг юм бол өөр жижиг ажил хийвэл болохгүй юу. Ажиллах боловсон хүчин хэрэгтэй, сайн ажилчид хэрэгтэй. Зээл авах талаар хөөцөлдсөн юм байна уу. Хувьцаа эзэмшигчид хуралдаа муу оролцож байна. Хуралд ирж байгаа хүмүүс нь ноогдол ашиг тараах тухай их асуух юм.

Р.Зоригт: Ш.Оюун-Эрдэнийг одоогоор ажиллуулж байхгүй бол өөр хүн алга. Харин цалин шийдэж өгөх гэхээр санхүүгийн хувьд боломжгүй байна. Энэ жил ч энэ байдал хэвээр байх бололтой тиймээс тэсэж байхыг хүсье. Тусгай зөвшөөрөл өгөхгүй байна. Төслийн ажлын хувьд бүтэмж муу байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байгаа.

Р.Алтанцэцэг: Зээлийн шаардлагад манай байгууллага нийцэхгүй байгаа. ТУЗ-н хувьд гишүүдээ ажлуулмаар санал бодлыг сонсож тусламж дэмжлэг авмаар байна. Р.Зоригт ТУЗ-н даргын хувьд ч хувьцаа эзэмшигчийн хувьд ч идэвхи гарган янз бүрийн юмны өмнө л байх юм.

Л.Мөнхтуяа: Миний хувьд биеийн эрүүл мэндийн байдлаас болоод хуралд муу оролцсон. Одоо хүн бүрийн хүчин зүтгэл хэрэгтэй гэж бодож байна.

Адил чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага хувь хүмүүстэй хамтарч ажил хийвэл болохгүй юу.

Л.Амарсайхан: Таны санал бас бодож үзмээр юм байна. Цаашид ямар ажил төлөвлөж байна вэ? Инженер, техникийн ажилтнууд байна уу?

Хувьцаа эзэмшигчид нь дандаа энэ байгууллагад ажиллаж байсан хүмүүс биздээ.

Р.Зоригт: Одоогийн инженер техникийн ажилтнууд цалин өндөртэйгээр бусад газруудад ажиллаж байна. Компанийн үйл ажиллагааг бол барилгын чиглэлийг нь

хадгалаад явна гэсэн бодолтой байгаа. Хувьцаат компанийн хувьд өөр чиглэлийн ажил хийнэ гэдэг хэцүү. Хөрөнгө оруулалтын ажлаа ийшээ чиглүүлнэ гэсэн бодолтой.

Р.Алтанцэцэг: Бид энэ компанийн ажлыг өөднө татаж цаашид юу хийж яаж ажиллах талаар сайн ярилцмаар байна. ТУЗ-н хурал хийхээр ирчээл бусад үед оролцоо муу байна.

Т.Бадамжунай: Би хурлын хэлэлцэж байгаа асуудалтай санал нэг байна. Хурлаас гарах шийдвэрийг дэмжинээ.

Д.Болорцэцэг: ТУЗ-ийн ажил муу байсан гэдгийг сануулах хэрэгтэй. Хөрөнгө оруулалт татах хэрэгтэй юм шиг санагдах юм. ТУЗ-н гишүүд идэвхи санаачлага муутай байна.

Миний хувьд жил бүр хуралд ирдэг. Хувьцаа эзэмшигчид шүүмжлээд байхаас биш бид ямар үүрэгтэй байх вэ яввал энэ байгууллагыг сайн болгох тухай олигтой санал хэлдэггүй. Зарим нэг хүмүүс нь бүр доромжлоод хурлаа хаяад гардаг. Сайн менежмент хэрэгтэй гэж бодож байна. Ямар менежментээр яаж ажиллах вэ гэдгийг ярилцах хэрэгтэй.

Г.Төгөлдөр: Туслаад дэмжээд ажиллах хүн алга. Бид энэ компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох боломж байдаггүй өөр өөрийн ажлаа хийгээл явж байдаг. Хувьцаа эзэмшигчид ноогдол ашиг тараах уу гэж их асуудаг байгууллагаа яаж ажилтай байлгах уу гэж боддоггүй. Зарим хувьцаа эзэмшигчид боломжтой хамтраад ажил хийвэл болох юм шиг санагддаг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн цаашдын зорилтыг хэлэлцэв. Компанийн цаашдын зорилтыг хэлэлцэн батлахтай холбогдуулан Р.Зоригт өөрийн саналаа хэлэв:

- 2024 онд Санхүүгийн байдлаа сайжруулах өр төлбөрийн асуудлаа шийдвэрлэх;
- Гадна болон дотор дулааны шугамын засварын ажлыг бүрэн дуусгах;
- ТУЗ н дэд хороодын ажлыг сайжруулж хөрөнгө оруулалт татах ажлыг судлаж шийдвэрлэх

Компанийн тухай хуулийн 77р зүйлийн 77.2 Компанийн дүрмийн 10.6 -д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-н гишүүдийн бүрэн эрхийн хугацааг дараагийн ээлжит хурал хүртэл сунгаж дэд хороодууд хуучин бүрэлдхүүнээрээ ажиллахаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал нэгтэй батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар тогтоол гаргахаар тогтож, тогтоолын төсөл бүрийг хэлэлцэж, тэдгээрийг санал нэгтэйгээр батлав.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 16.00 цагт дуусав.

ХУРЛЫН ДАРГА

Р.Зоригт

Р.Зоригт

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН *Д.Болорцэцэг* Д.Болорцэцэг

